

Монголын философийг 1990 –ээд оноос хойш судалж ирсэн зарим бүтээлийн арга зүйн асуудалд

On the methodological problems of some works which have been studying Mongolian philosophy since the 1990s

Сүхбатын Соёлмаа¹

Доктор (Ph.D)

Шинжлэх Ухааны Академийн

Философийн хүрээлэн

Философийн салбар

soyolmaas@mas.ac.mn

Soyolmaa Sukhbat

Doctor (Ph.D)

Department of Philosophy,

Institute of Philosophy,

Mongolian Academy of Sciences

soyolmaas@mas.ac.mn

Хураангуй:

Энэ өгүүлэлд бид Монголын философийг судалсан 1990-ээд оноос хойших судалгаа шинжилгээний зарим бүтээлүүдийн арга зүйг товч авч үзээд улмаар философийн шинэлэг арга зүйн хандлагыг санал болгохыг зорьсон юм. Бид мэргэжлийн байгууллагын эрдмийн зөвлөлөөр хэлэлцүүлж батлуулсан, олон нийтэд хүлээн зөвшөөрөгдсөн, докторын зэрэг хамгаалсан эрдэмтэн, философичдын бүтээлийг сонгон авч хэлэлцэхийг хичээсэн юм. Эдгээр бүтээлүүдийн Монголын философи, ерөөс философи хэмээх ойлголтыг хэрхэн авч үзсэнийг хэлэлцэж, зөвхөн арга зүйн судалгаанд анхаарлаа хандуулсан. 1990-ээд оноос хойш Монголын философийг түүхэн-харьцуулалтын аргаар судлах туршлага зонхилж байна. Мөн судлаач эрдэмтэдийн дийлэнх нь Монголын философийг нийгэм-улс төрийн харилцаанд (нийгмийн бүлэг хоорондын харилцааны утгаар биш) эсвэл Буддын шашны хүрээнд авч үзсэн нийтлэг хандлага байна. Хэлэлцүүлгийн үр дүнд

Abstract:

In this article, we would like to briefly consider the experience of studying Mongolian philosophy since the 1990s, and then propose some new methodological approaches. When we selected some of the works that have studied the Mongolian philosophy since the 1990s, we tried to choose the works of scientists and philosophers who have been discussed and approved by the academic council of the professional organization, are recognized by the public, or have received their doctorates. In these works, we carefully considered the experience of dealing with philosophy, and focused only on methodological issues. Since the 1990s, the experience of studying Mongolian philosophy through historical-comparative methods has been predominant. Also, there is a common tendency that most of the research scientists considered Mongolian philosophy only in terms of socio-political relations or in the context of Buddhist religion. In the result of discussion, we came to a conclusion that it is important to study Mongolian philosophy in the sense

¹ © Зохиогч. 2022. Сэтгүүлд нийтлэгдсэн эрдэм шинжилгээний бүтээл нь зохиогчийн оюуны өмч байх бөгөөд (CC BY-<https://creativecommons.org/licenses/by/4.0/>) нөхцөлийн хүрээнд ашиглана уу.

Монголын философийг бүтээлч, ойлголтын утгыг нээдэг, асуудал шийддэг, шинэ ухагдахуун нээдэг гэдэг утгаар нь судлах нь чухал, мөн Монголын философийг судлахад хүмүүнлэг, соёлын байр суурийг баримталж, феноменологи, герменевтик, бүтэц тэмдэг зүйн болон түүхэн харьцуулалтын гэх мэт философийн онцлог бүхий арга зүйг хослуулах нь зүйтэй юм гэсэн дүгнэлтэд хүрсэн юм.

Түлхүүр үгс: Монгол, философи, түүх, логик, бүтэц, ойлголт, утга, арга, бүтээл, үйл явц

that it is a creative finding, discovers the meaning of concepts, modernizes, solves philosophical fundamental problems, and opens new concepts. When studying Mongolian philosophy, it is advisable to adopt a humanistic and cultural position and combine the methodology with the characteristics of philosophical methods such as phenomenology, hermeneutics, structure-symbolism, and historical comparison.

Keywords: Mongolia, philosophy, history, logic, structure, conception, method, creation, process

I. Оршил

Монгол Улсын Шинжлэх Ухааны Академийн Философийн хүрээлэнгийн болон бусад их дээд сургууль, эрдэм шинжилгээний байгууллагуудын эрдэмтэн, судлаач, философичид, мөн гадаадын эрдэмтэн судлаач нар Монголын философийг судалсаар ирсэн. Гэвч Монголын философийг бие даасан философийн хөгжил гэх байдлаар ойлголтуудыг нь эдүгээчлэн тайлбарласан, Монголчуудын философийн онцлогийг нь дэлхийн философийн ололт амжилттай харьцуулан шинжилж, өөрийн чанарыг нь нээн илрүүлэх шаардлага улам бүр нэмэгдсээр байна. Тийм учраас бид энэхүү өгүүлэлдээ Монголын философийг 1990-ээд оноос хойш судалж ирсэн туршлагыг товч авч үзээд улмаар арга зүйн зарим шинэ хандлага байх боломжтой тухай санааг дэвшүүлэх гэсэн юм.

II. Судалгааны арга зүй

Бид монголын философийг 1990-ээд оноос хойш судалж ирсэн зарим бүтээлийг сонгохдоо мэргэжилийн байгууллагын эрдмийн зөвлөлөөр хэлэлцэж баталж хэвлүүлсэн, олон нийтэд хүлээн зөвшөөрөгдсөн буюу доктор хамгаалсан эрдэмтэн, философичидын бүтээлийг сонгон авч судлахыг чухалд үзлээ. Өөрөөр хэлбэл, мэдлэгийн легитимац (хууль ёсны, албан ёсны) зарчмыг баримталсан гэсэн үг юм. Мөн эдгээр бүтээлүүдийн зөвхөн судалгааны арга зүй дээр л төвлөрч, ялангуяа Монголын философийг, ерөөс философийг хэрхэн авч үзэж ирсэн туршлагыг нь нягтлан авч үзэхийг зорьсон юм. Арга зүйн хувьд он цагийн дарааллынх нь хувьд түүхчлэн, бүх зохиол бүтээлийн агуулгыг авч үзэхийг зорьсонгүй, гагцхүү “монголын философи” гэх тодотголтой зарим бүтээлүүдийн арга зүйг сонгон авч хэлэлцэхийг зорьсон болно.

III. Судалгааны үр дүн

Энэ өгүүлэлд бид философи гэх ойлголтыг орчин үеийн философичидийн шинэлэг бүтээлүүдийг судлан шинжилсний үндсэн дээр дараах байдлаар авч

үзэх нь зүйтэй гэсэн дүгнэлтэд хүрч байгаа юм. Философийн онцлог арга зүй бол шинжлэх ухааны, тэр дундаа байгалийн шинжлэх ухааны арга зүйгээс хамгийн гол ялгарах онцлог нь философийн концептийн (ойлголтын утгын) онцлог шинжтэй холбоотой юм. Философийн үндэслэгээ бол ойлголтын утгыг бүтээж, түүгээрээ сэтгэж, дахин өөр шинэ ойлголтын утгыг бүтээж, төлөвшүүлэх үйл явц юм. Мөн шинжлэх ухааны нэр томъёоноос ялгаатай нь философийн концепт нь зөвхөн сэтгэхүйн үр дүн төдийгүй, шаналал, амсаж туулахуй, санаа зовнил зэрэг сэтгэлийн үйл байх бөгөөд чанд оюун ухаан логикийн хэл төдийгүй, уян зөөлөн ярианы үйл байдаг юм. Философийн концепт бол асуудал болон асуудлуудад ханддаг, шинжлэх ухаанаас ялгаатай нь тогтмол эсвэл хувьсах шинжтэй бус, харин үргэлжлэх, шилжимтгий шинжтэй, мөн хувь, дахин давтагдашгүй шинжтэй юм. Монголын философийг 1990-ээд оноос хойш түүхэн-харьцуулалтын аргаар судалж ирсэн туршлага ихэвчлэн зонхилж ирсэн байна. Мөн судлаач эрдэмтэдийн ихэнх нь монголын философийг зөвхөн нийгэм улс төрийн харилцаагаар нөхцөлдөж (нийгмийн бүлэг хоорондын харилцаа гэдэг утгаар бус) байсан сэтгэлгээ, эсвэл буддын шашны хүрээнд авч үзсэн нийтлэг чиг хандлага ажиглагдаж байгаа юм. Харин бид монголын философийг бүтээлч, ойлголтын утгыг илрүүлдэг, эдүгээчилдэг, асуудлыг шийддэг, шинэ ухагдахуун ойлголтыг нээдэг гэсэн утгаар ойлгож феноменологи герменевтик болон судлагдахуунд объектив байдлаар ханддаг бүтэц-тэмдэг зүйн, нөгөө талаас монголын философийн онцлогийг илрүүлэх түүхэн харьцуулалтын зэрэг аргуудыг хослуулан судлах нь чухал юм гэсэн дүгнэлтэд хүрсэн юм.

IV. Судалгааны хэлэлцүүлэг

Монгол угсаатнууд Монголын газар нутагт суурьшин амьдарч эхэлсэн цагаас (Хүннү, Сүннүгийн үеэс) хүний амьдрал, оршинхуйн утга учир, танин мэдэхүй, мэдлэгийн үнэний шалгуур, хүний амьдралын үнэт зүйл, эрхэмлэл зэрэг философийн ойлголтыг боловсруулж, бүтээж, төлөвшүүлж ирсэн нь, мөн философийн ойлголтын тогтолцоонд хувь нэмэр оруулж ирсэн. Гагцхүү судлаачид бид үүнийг нухацтай уйгагүй мөшгин судлах нь чухал юм. Монголчуудын амьдралын хэв маягтай холбоотойгоор философийн өв, эх сурвалжийн багагүй хэсэг нь гээгдэж үгүй болсон хэдий ч аман ба бичгэн хэлбэрээр үлдэж хоцорсон философийн эх сурвалжууд монголчуудын дунд цөөнгүй өвлөгдөн ирснийг эрдэмтэн мэргэд, философичид тэмдэглэсээр ирсэн билээ. Монголын философид эртний Энэтхэгээс Төвдөөр дамжиж орж ирсэн, буддын философийн тайлбар зохиолууд асар их хувь нэмэр оруулсан. Гэхдээ Монголын философийг зөвхөн эдгээр буддын уламжлал бүхий зохиолуудын хүрээнд авч үзэх нь хангалтгүй юм. Харин Монголын философийг тодорхой асуудалд чиглэсэн, үүнийг шийдвэрлэсэн, тодорхой ойлголтыг бүтээсэн, түүгээрээ сэтгэсэн, сэтгэлгээний түүхэнд тодорхой үсрэлт, хөгжил, өөрчлөлтийг авчирсан гэх зэрэг арга зүйн хандлага, зарчмуудын үүднээс судлах нь зүйтэй. Монголын буддын философийн судалгаа шинжилгээний сүүлийн үеийн зарим бүтээлд байх арга зүйн нийтлэг алдаа бол нэгдүгээрт, буддын шашны ойлголтуудыг философи, шинжлэх ухаан, иргэний утга руу хөрвүүлдэггүй; хоёрдугаарт, монголын философийг шашны уламжлал, догма!

байдлаар тайлбарладаг; гуравдугаарт, монголын буддын философийн онцлогийг дэлхий нийтийн, бусад ард түмний болон соёл иргэншлийн философитой харьцуулж, онцлог шинжийг нь нээн гаргаж ирдэггүй зэрэг болно. Хөндлөнгийн уншигч ийм маягийн судалгааны номыг уншихаараа Монголчууд бие даасан философигүй, харин төвдөөс уламжилж ирсэн философийг л тайлбарласан төдий юм гэх ойлголттой үлдэх нь бий. Философийг шашны догматик сургаал байдлаар ойлговол өрөөсгөл болох бөгөөд философийн концепт бол өөрчлөгдөн хувьсах сэтгэлгээ гэдгийг ямагт санах нь философийн арга зүйн чухал зарчим билээ. Монголын философи нь шашны шинжтэй байсан үе байх хэдий ч дан ганц ийм байдаг гэвэл ихээхэн өрөөсгөл шинжтэй юм. Бидний үзэж байгаагаар Монголын философийн уламжлал бол домог, шашин, шинжлэх ухаан, яруу найраг, утга зохиол гэх мэт биет ба биет бус соёлын олон талт харилцаа байж ирсэн билээ. Философи бол соёлын эдгээр хэлбэрүүдтэй хосолж, эсвэл аль нэг шинжийг нь илүү өөртөө хадгалдаг, эсвэл соёлын эдгээр хэлбэрүүд нь монголын философийн онцлог шинжийг өөртөө агуулдаг билээ.

Эрдэмтэн, философич Ч.Жүгдэр бол монголын философийг түүхэн харьцуулалтын аргаар судалж, шинжилсэн томоохон эрдэмтэдийн нэг билээ. Тэрээр “Монголын нийгэм-улс төр, философи сэтгэлгээний хөгжил (МЭӨ III-МЭ XX зуун)” гэсэн бүтээлдээ Монголын философийг судлахдаа түүхэн арга зүйг баримталсан гэдгээ илэрхийлсэн байгаа бөгөөд түүхэн арга зүйн давуу талуудын тухай өгүүлжээ. Тухайлбал, тэрээр бичихдээ “түүхэн ёсоор тодорхой хандах нь өнгөрсөн үзлүүдийг тодорхойлоход субъектив үнэлэлт өгөх, түүний түүхийг “сайжруулах”, “муутгах” оролдлогоос судлаачийг аварч, марксизм-ленинизмийн тууштай байр сууриас задлан шинжилж, шинжлэх ухааны шүүмжлэлт үнэлэлт дүгнэлт өгөх боломжийг олгодог болно”[1] гэжээ. Тэгэхээр түүхэн үүднээс хандах арга зүйн онцлогийг Ч.Жүгдэр нь субъектив үнэлэлт өгөхөөс судлаачийг аварна гэж үзэж байгаа нь аливаа судлагдахуунд объектив, үнэн бодитой хандахын чухлыг онцолж байгаа хэдий ч бүтээлч хандах, асуудлыг шийдсэн байдал, ач холбогдлыг нь товойлгох зэрэг судалгаа шинжилгээний чухал шинжүүдийг орхигдуулсан байх талтай юм. Тухайлбал, тэрээр монголын философийг “Монголын философи, нийгэм-улс төрийн сэтгэлгээний түүх” номондоо авч үзэхдээ түүхэн үеүүдэд үечлэн авч үзээд, тухайн түүхэн үе нь өөр өөрийн онцлог шинжтэй тухай өгүүлсэн байна. Ер нь Жүгдэр нь философийг хэрхэн ойлгож Монголчуудын сэтгэлгээний түүхийг авч үзсэн бэ гэдгийг түүний “Монголын философийн түүхийг судлах арга зүйн зарим асуудал” гэсэн эрдэм шинжилгээний өгүүллээс харж болох юм. Үүнд, “Монголын философийн түүх гэдэг бол товчдоо манай ард түмнээс бодит ертөнцийг танин мэдэхийн төлөө явуулсан их тэмцлийн хураангуй дүн мөн”[2] гэжээ. Энэ ишлэлд тэрээр философийг бодит ертөнцийг танин мэдэхүй хэмээн үзсэн байна. Физик, хими гэх мэт ер нь аливаа байгалийн шинжлэх ухааны судлагдахуун бол бодит ертөнцийг танин мэдэж, түүний хуулиудыг илрүүлэхэд оршдог. Мөн байгалийн шинжлэх ухаан эсвэл, байгалийн шинжлэх ухааны арга зүйг хэрэглэдэг позитив чиглэлтэй нийгэм хүмүүнлэгийн бусад шинжлэх ухаан бол бодит байдлын утга учрыг хайх, түүний хууль зүй тогтлыг эрэлхийлдэг. Тухайн шинжлэх ухааны судлагдахуунаас хамаараад шинжлэх ухааны бодит

байдлууд нь өөр өөр байдаг. Тухайлбал, улс төр судлалын хувьд засаглагч ба засаглуулагч нарын харилцаа нь бодит байдал болдог гэх мэт. Харин философи бол анхнаасаа бодит ертөнцийн уг суурь болж байдаг, цаана эсвэл нөгөө хэмээх ахуйг, мөн энэ нь бодит ертөнцтэй ямар холбоо хамааралтай байдгийг (энэхүү цаана ахуй нь бодит ертөнцийн цаана тусдаа байдаг уу, эсвэл бодит ертөнцтэй зэрэгцээ оршдог юм уу, эсвэл түүний үндэс суурь нь болдог юм уу гэх мэт) үндэслэхийг зорьдог билээ. Тийм ч учраас сонгодог философийг метафизик хэмээн нэрийддэг. Мета гэдэг нь дараа, харин физик бол бодит зүйл бөгөөд метафизик бол бодитын дараах, цаана байгааг үндэслэдэг ухаан юм. Орчин үеийн, сонгодог бус философи нь хэдийгээр метафизикийн байр суурийг шүүмжилдэг хэдий ч, “нөгөө”, “цаана байх”, “суурь” болж буй гэсэн ойлголтыг мөн адил авч үзэж байгаа юм. Жишээ нь, Юнг болон Фрейд нь ухамсаргүйн тухай; Леви-Стросс ба түрүү үеийн Витгенштейн нь метакэлний тухай; Гуссерль нь цэвэр ухамсрын тухай; прагматик ба утилитаризмд нийтийн ашиг, аз жаргалын тухай; постмодернизмд бүтцийн гадна байх нарративуудын тухай авч үздэг гэх мэт.

Философи бол амьдралыг ойлгох үйл явц юм гэсэн байр суурийг герменевтик арга зүйг үндэслэгч Шлейермахер болон Хайдегер нар баримталдаг. Тэд байгалийн шинжлэх ухаанаас нийгэм хүмүүнлэгийн шинжлэх ухааны арга зүйг ялгаж үзэхдээ “Байгалийн шинжлэх ухааны танин мэдэхүйн арга нь энгийн эмпирик шинжтэй байж болно. Харин хүмүүнлэгийн болон нийгмийн шинжлэх ухааны арга нь зөвхөн герменевтик арга байх бөгөөд герменевтикийн зорилго бол зөвхөн үзэл санааг төдийгүй, хүний амьдралыг ойлгох зорилго юм”[3] гэжээ. Ч.Жүгдэр мөн өгүүлэлдээ “...философи сэтгэлгээ бол нийгмийн ахуйд нийгмийн ухамсрын харилцах тодорхой харилцааны бүтээгдэхүүн, байгаль нийгэм дэх объектив бодит байдлын тусгал, уг ард түмний бодит ёсоор нөхцөлдөж, түүхэн ёсоор хөгжиж ирсэн ухамсар мөн”[4] хэмээн дүгнэсэн байна. Энэ ишлэлээс дүгнэхэд Ч.Жүгдэр нь философийг зөвхөн үзэл санаа гэхээс илүү амьдралыг ойлгох ухамсар хэмээн үзсэн түүний монголын философийг судлан шинжилсэн арга зүйн шинэлэг, орчин үеийн хандлагыг мөн илэрхийлж байгаа юм.

Мөн Ч.Жүгдэр нь монголын философийн түүхийг судлахдаа шашин ба философи гэх ойлголтуудыг тодорхой ялгаагүй нь Монголын философийг дорнын философийн уламжлалтай хэмээн үзсэнтэй нь холбоотой. Ерөөс дорнын философи бол интуитив, мөн шашинлаг шинжтэй гэдгийг олон судлаач, эрдэмтэд тэмдэглэсэн байдаг. Францын философичид Ж.Делёз, Ф.Гваттари нар нь “Философи гэж юу вэ” зохиолдоо дорнын философийг шашин хэмээн тодорхойлсон байдаг. Гэвч бидний үзэж байгаагаар дорнын философи бол шашинлаг шинжтэй байж болох хэдий ч бас шинжлэх ухаанч шинжийг ч өөртөө агуулдаг юм. Энэ тухай эрдэмтэн Жүгдэр бичихдээ “шашны үзэлтэй эрдэмтэд тодорхой үзэгдлийг шинжлэх ухааны үүднээс бодитойгоор тайлбарласан явдал түүхэнд олон буй”[5] гэжээ. Энэ ишлэлд тэрээр шашин гэх ойлголтыг шинжлэх ухааны чиг баримжаатай, харин далдыг шүтэх төдий биш юм гэсэн байр суурийг баримталсан байгаа нь шашинд хандах орчин үеийн сонгодог бус философийн үүднээс авч үзсэн түүний арга зүйн давуу тал харагдаж байна. Мөн тэрээр энэ өгүүлэлдээ “харанхуй бүдүүлэг байдал,

шашныг хэт баримтлагч үзэл, элдэв хоцрогдлын эсрэг...гэгээрүүлэгчид, дэвшилт ардчилсан үзэлтнүүд...хөрс дэвсгэрийг бэлтгэсэн байна”[6] гэсэн байна. Эндээс дүгнэхэд Жүгдэр нь шашныг хэт баримтлагч нь, өөрөөр хэлбэл шинжлэх ухаанч чиг баримжаагүй шашин бол гэгээрүүлэгч эсвэл дэвшилт ардчилсан үзэлтэй биш гэх зэргээр шашны шинжлэх ухаанч чиг баримжаатай байхын чухлыг онцолсон байна.

Эрдэмтэн, философич Д.Дашпүрэв нь “Монголын философийн товч түүх” гэсэн бүтээлдээ Монголын философийн үзэл санааг авч үзэхдээ мөн л түүхэн-харьцуулалтын аргаар авч үзсэн боловч Ч.Жүгдэрээс арай өөр байдлаар Монголын философийн түүхийг үечилжээ. Тухайлбал, өвөг монголчуудын угтал философийн үзэл санааны тойм (нэн эртнээс МЭӨ III зуун), Эртний монголчуудын мөнхийн философийн үзэл санааны тойм (МЭӨ III зуунаас МЭ XII), Чингисийн их гүрний монголчуудын философийн үзэл санааны тойм (1206-1260), Юань гүрний монголчуудын философи сэтгэлгээний тойм (1260-1368), Хаант монгол улсын монголчуудын философи сэтгэлгээний тойм (1368-1758), Манжийн ноёрхолын үе дэхь монголын философи, улс төр, нийгмийн сэтгэлгээ (1758-1911), Богд хаант монгол улсын үед монголчуудын нийгмийн ухамсар, оюун санаанд гарсан өөрчлөлт (1911-1921), социалист монголын философи (1921-1990), Шинэ зууны монголын философийн эхлэл (1990 ээд оноос хойш) гэх мэтээр түүхэн байдлаар үечлэн авч үзсэн байна. Энд ч мөн Монголын философийг түүхчлэн үечлэхдээ нийгэм улс төрийн байгууламжийн талаас авч үзсэн өнгө аяс харагдаж байгаа юм. Гэхдээ тэрээр философийг философийн асуудлыг тусгай ухагдахууны тусламжтайгаар шийдвэрлэдэг сэтгэлгээ талаас нь авч үзэхийг зорьсон байна. Тухайлбал, тэрээр бичихдээ “манай өвөг дээдсийн үлдээсэн зохиол бүтээлүүдэд “ахуйн, “оршихуй”, “учир шалтгаан”, “сэтгэхүй”, “ухамсар”, “би”, “хууль”, “логик” гэсэн философийн тулгуур асуудлуудыг тусгайлан авч үзсэн, судалсан байдал их л хожуу үеэс ажиглагдах ажгуу”[7] гэсэн байна. Энэ нь философийн концепт бол асуудал болон асуудлуудад ханддаг гэсэн шинэлэг арга зүйг сануулж байгаа юм. Тийм учраас Д.Дашпүрэв бол монголын философийг хэдийгээр түүхэн харьцуулалтын аргаар авч үзсэн боловч философийг ухагдахууны тусламжтайгаар асуудлыг шийдвэрлэдэг гэсэн талаас нь ойлгож монголын философийг товч түүхийг авч үзсэн байна. Энэ нь түүний арга зүйн онцлог бөгөөд шинэлэг талыг илтгэж байгаа юм.

Мөн Монгол Улсын Шинжлэх Ухааны Академийн Философи, социологи, эрхийн хүрээлэнгээс гаргасан “Монголын философийн түүх” дөрвөн боть зохиолд эртний Монголчуудын ертөнцийг үзэхүй, Монголын философийн түүх (XIII-XVIII зуун), Монголын философийн түүх (XVII-XIX зуун) гэсэн үечлэлд хуваан үзэж Монголын философийг шинжилсэн байна. Энэ бүтээлд монголын философийг мөн түүхэн харьцуулалтын аргаар авч үзсэн байгаа юм. Гэсэн хэдий ч энэ бүтээлийн арга зүйн нэг давуу тал нь түүхэн харьцуулалтаар үечлэхийн зэрэгцээ нийгэм улс төрийн, зан суртахууны, гоо сайхны, буддын гүн ухааны зэргээр философи мэдлэгийн бүтцээр ангилан авч үзэнд байгаа юм. Мөн тус бүтээлийн IV дүгээр бүлэгт Монголын буддын гүн ухааны зарим төлөөгчийн үзэл санааг намтарчилсан байдлаар авч үзсэн нь мөн арга зүйн хувьд сонирхолтой, шинэлэг болжээ. Гэсэн хэдий ч энэхүү дөрвөн боть бүтээлд

арга зүйн дутагдал бас байгаа бөгөөд, жишээ нь, түүхэн үечлэл бүрийн философийн сэтгэлгээг авч үзэхдээ логикийн хувьд ойлгомжгүй, эмх цэгцгүй, бүлэг зүйл бүр нь агуулгын хувьд уялдаа холбоо муутай байгаа юм. Жишээ нь, Монголын философийн түүх-II дэвтэрт “Монголын нууц товчоо” зохиолын үзэл санаа гэсэн нэг бүлэг байхад “Эзэнт гүрний үеийн монголын философийн сэтгэлгээн дэх буддын чиглэл” гэсэн нөгөө бүлэг зэрэгцэн байгаа нь агуулгын хувьд логик муутай байгаа юм. Нэг бүлэг нь зөвхөн нэг зохиолын тухай өгүүлсэн байхад нөгөө нэг бүлэг нь бүхэл бүтэн философи сэтгэлгээний нэг айл авч үзсэн байх жишээтэй. Харин үүний оронд бүлгүүдийн хуваарилалтыг айл болгож хуваагаад, үүндээ зохиол бүтээлийн тайлбараа багтаасан бол оновчтой байх байсан. Гэхдээ энэ бүтээл бол Монголын философийн чиглэлээр 1990 ээд оноос хойш бичсэн бүтээлүүдээс арга зүйн хувьд хамгийн шинэлэг бөгөөд агуулгын хувьд даацтай бүтээл болж чадсан юм. Харин энэ боть зохиолыг цаашид чамбайруулан дахин нягталж арга зүйг нь сайжруулах шаардлагатай байгаа юм.

Эрдэмтэн, философич Ч.Ган-Өлзий нь “Монгол хүний сэтгэлгээний өөрчлөлт хөгжил” гэсэн номондоо сэтгэлгээ хэмээх ойлголтыг “философийн утгаар хэрэглэж буй... энд шинжлэх ухааны сэтгэлгээний тухай хөндөөгүй нь ойлгомжтой”[8] гэсэн байна. Энэ ном нь арга зүйн хувьд сэтгэлгээг зөвхөн рациональ түвшинд, тооцоолон бодохуй гэхээс илүү өргөн хүрээнд, өөрөөр хэлбэл шүтлэг, сүсэг бишрэл, домог, төр, хууль, философи гэх зэргийг багтаасан байдлаар Монгол хүний сэтгэлгээний жишээн дээр авч үзсэн байгаа нь арга зүйн хувьд герменевтик байр суурь, соёлын хандлагаар монголын философийг авч үзэж, шинжлэх оролдлого болжээ. Мөн энд философийг шашнаас ялган үзэж илүү шинжлэх ухаанч сэтгэлгээтэй ойртуулсан байдлаар эцээн мэргэн сэтгэлгээ, эргэцүүлэн бодох урлаг, шүтэн барилдахуйг онох арга зүй хэмээн авч үзсэн байна. Гэхдээ философийг л зөвхөн эцээн мэргэн ухаан гэж ойлгож болохгүй бөгөөд яруу найрагч, эрдэмтэн, төмрийн дархан, уран бүтээлч, харваач, бөх гэх мэт хэн ч эцээн мэргэн ухаантай байж болно. Харин зохиогч дараа нь философийг тусгай шинжлэх ухаанаас ялган үзэж “философи сэтгэлгээ гэдэг нь хүрээлэн байгаа орчныг ухамсарлан ойлгох оюун ухааны үйл ажиллагааны онцгой хэлбэр бөгөөд хамгийн гол шинж чанар нь тусгай тусгай олон нэгж юмсад хамгийн ерөнхий түгээмэл хэлхээ холбоо, харилцааг олж харах чадвар амой”[9] гэсэн байна. Энд харин оюуны соёлын хэлбэрүүдээс философи юугаараа ялгардаг юм бэ гэдгийг илүү тодорхой авч үзсэн байгаа юм. Зохиогч философийг ийнхүү тодорхойлоод номын “Философи сэтгэлгээ” хэмээх гуравдугаар бүлгийн “Сэцэн мэргэн сэтгэлгээ, түүний онцлог” гэсэн ганц зүйлд л “Чингисийн есөн өрлөгтэй өнчин хүүгийн сэцэлсэн шастир”, “Оюун түлхүүр” гэх хоёр бүтээлд сэцэн мэргэн ухааныг хэрхэн авч үзсэн тухай өгүүлжээ. Гэвч бас номын бүлэг зүйлийн нэрс нь номын ерөнхий нэртэйгээ дүйцэхгүй байгаа дутагдал харагдаж байна. Жишээ нь, номын гарчиг бол “Монгол хүний сэтгэлгээний өөрчлөлт” гэсэн нэртэй байгаа боловч бүлгүүд нь “Сэтгэлгээний философи”, “Сэтгэлгээний үндсэн хэлбэрүүд”, “Философи сэтгэлгээ”, “Сэтгэлгээний хөгжлийн үндсэн чиглэл” зэрэг хэт ерөнхий нэршилтэй байна. Арга зүйн хувьд зохиогч философийг хэрхэн үзэж байгаагаа сэтгэлгээний бусад хэлбэрүүдтэй харьцуулан тодорхой болгож, монгол хүний

сэтгэлгээг авч үзсэн нь шинэлэг бөгөөд ач холбогдолтой байгаа юм. Мөн философич нь философийг утгыг эрэлхийлэх үйл явц, диалог, монолог, олон нийтийн хэлэлцүүлгийн үйл явц хэмээн үзсэн нь түүний сүүлийн үеийн эрдэм шинжилгээний илтгэл, өгүүлэлд илүү тодорхой харагддаг. Жишээ нь, тэрээр “Аргусун хуурчийн домог” хэмээх зохиолыг XIII зууны эхэн үеэс бидэнд уламжлагдан ирсэн философи, яруу найргийн цөөхөн дурсгалын нэг [10] хэмээн үзсэн байна. Мөн философи нь хэлэлцүүлэг байдлаар Монголын философийн түүхэнд хэрхэн илэрч байсныг “Чингисийн есөн өрлөгтэй өнчин хөвгүүний сэцэлсэн шастир”-аар төлөөлүүлэн авч үзсэн байгаа нь арга зүйн хувьд оновчтой сонголт болжээ. Энэ зохиолын “Өнчин хүү” гэх гол баатар сархад уух мөн чанарыг хэлэлцэж байгаа арга нь Сократын философийн арга зүйг санагдуулж байгаа юм. Тэрээр энэ тухай бичихдээ “Үнэн хэрэгтээ яруу найргийн энэ шастарт Чингис хаан өөрийн есөн өрлөг, таван тайж ба “өнчин хүүтэй” ярилцсан жирийн ярианы тухай биш, харилцан ярилцсан тухай (dialogue) өгүүлжээ... Ийм байр сууринаас үзвэл энэ шастарын философийн ач холбогдол илүү тод харагдах болно”[11] гэсэн байна. Гэхдээ философийн концепт бол хувь шинжтэй, дахин давтагдашгүй гэдгийг бас санах хэрэгтэй. Ийм байр суурийн үүднээс тус шастирыг философийн эх сурвалж гэж авч үзэхэд зохиогчийн асуудал гарч ирж болох юм. Энэ шастирын зохиогч нь хэн байсан тухай Ган-Өлзий энэхүү өгүүлэлдээ тодорхой авч үзээгүй байгаа юм. Жишээ нь энэ зохиолыг XIII зууны үед бичигдсэн[12] хэмээсэн боловч зохиогчийг тодорхой дурдаагүй байна. Зохиогч нь тодорхойгүй учраас энэ зохиолыг Чингис хааны философи ч гэж үзэх туйлширсан хандлага байсаар байна. Тиймээс хэн гэдэг Монголын философич энэ зохиолыг бичсэнийг тодруулах нь цаашдын бүтээлч судалгааг шаардаж байна.

Харин философийг ерөөс шинжлэх ухааны логик арга зүй болдог гэсэн байр суурийг академич Г.Чулуунбаатар “Шинжлэх ухааны танин мэдэхүйн логик, судалгааны ажлын арга зүй” гэсэн бүтээлдээ илэрхийлсэн байна[13]. Энэ байр суурь бол Моррис Шликийн логик позитивист байр суурьтай төстөй байгаа бөгөөд тэр философийг сэтгэл судлал болон социологи гэх мэт эмпирик шинжлэх ухаанаас ялгаатай хэмээгээд, шинжлэх ухааны логик[14] хэмээн тодорхойлсон байдаг. Эрдэмтэн дурдсан бүтээлдээ философийг ерөөс логик шинжлэл юм хэмээн дүгнэсэн байгаа нь оновчтой болсон хэдий ч түүхэн харьцуулалтын аргыг логик аргаас ялгаж үзээгүй байна. Тухайлбал, тэрээр бичихдээ “Мөнхийн хөгжил өөрчлөлтөд оршиж буй судалгааны объектыг орон зай ба цаг хугацааны түгээмэл хэмжүүрт тодорхой баримтуудын учир зүйн гаргалгаа хийх сэтгэхүйн логик аргыг түүхэн ба логик арга гэнэ”[15] хэмээн бичсэн байна. Энд тэр философийн арга зүй, шинжлэх ухааны арга зүйн ялгаатай талыг тэр бүр тодорхой болгоогүй байгаа юм. Түүхэн харьцуулалтын аргыг философийн нэвтэрхий толь бичигт логик аргад эсрэгцүүлэн авч үзсэн байна. Жишээ нь, логик арга бол түүхэнд байх тогтолцоонуудын нэгдмэл бүтцийг хангахад, өөрөөр хэлбэл судлагдахууныг зэрэгцээ цагийнх болгож, бүхэл байдлаар хардаг бол түүхэн арга нь цуваа цагийн хэмжүүрээр, он дарааллынх нь хувьд тодорхой утгад илүү анхаардаг [16] зэргээр ялган үзсэн байна. Мөн академич дурдсан номондоо “Үнэний тухай асуудал мөн л шинжлэх ухааны ба философийн мөнхийн асуудал юм”[17] гэсэн байна. Гэтэл аналитик

философич нар үзэхдээ философийн арга зүй бол утгыг нээхэд чиглэдэг бол шинжлэх ухааны арга зүй нь үнэнийг нээх зорилготой[18] хэмээн философи ба шинжлэх ухааны арга зүйн ялгаатай талыг тодруулсан байна.

Эрдэмтэн, философич Г.Лодой “Шинжлэх ухааны судалгааны логик-арга зүйн асуудлууд” гэсэн номондоо түүхэн харьцуулалтын аргыг бие даасан утгаар авч үзсэнгүй, харин харьцуулан жиших оюун дүгнэлтийн аргыг логикийн аргын нэг хэлбэр байдлаар авч үзсэн байна. Мөн энэ номонд бүтэц тэмдэг зүйн аргаас гадна герменевтик аргын онцлогийн тухай сонирхолтой дүгнэлтүүдийг хийсэн байна. Жишээ нь, “шинжлэх ухааны судалгааны өмнөх үеийн үр дүнг орчин үеийн асуудлыг шийдвэрлэхэд “зөөн буулгаж” шинэчлэн хэрэглэх нь арга зүйн баримтлалыг зөв сонгон тодорхойлоход чухал үүрэгтэй”[19], “түүхийн судалгаанд объектив хандах зарчим, бүтээлч хандах зарчим хоёрыг хослуулан хэрэглэх нь ач холбогдолтой юм”[19] хэмээн бичсэн байна. Түүхийн судалгаанд объектив хандах зарчмыг нь бүтэц шинжлэлийн философийн арга зүйд баримталдаг бол харин бүтээлч хандах зарчмыг нь феноменологи, герменевтик философид баримталдаг билээ. Зарим талаараа герменевтик нь экзистенциализм болон аналитик философийн төлөөлөгч, хожуу үеийн Витгенштейний зарчмуудтай төстөй байдаг. Хожуу үеийн Витгенштейний үзлээр хэлний утга түүний хэлэгдэх нөхцлөөс хамаардаг, уян хатан шинжтэй юм. Гэвч Г.Лодойгийн дээрх номонд философийг шинжлэх ухааны ерөнхий арга зүйн зарчим байж болно гэсэн хэдий ч байгалийн шинжлэх ухааны арга зүй, философийн арга зүй хоёрын ялгаатай талыг тэр бүр тодруулаагүй дутагдал харагдаж байгаа юм. Философи бол рациональ-логик сэтгэлгээ ба мэдрэмж-туршлагыг хослуулах замаар амьдралыг ойлгох, ухаарах үйл явц гэсэн утгаараа шинжлэх ухаанаас ялгаатай юм. Бид дараагийн судалгаандаа философи шинжлэлийн арга зүйн тухай илүү тодорхой авч үзэх учраас энэ хэлэлцүүлгээ зөвхөн монголын философийг судлан шинжилсэн зарим бүтээлийн арга зүйн хүрээгээр хязгаарлаж байна.

V. Дүгнэлт

1990 ээд оноос хойш Монголын философийг судалж ирсэн зарим бүтээлийн арга зүйд давамгайлсан түүхэн харьцуулалтын аргыг бид огт үгүйсгэхгүй. Гэхдээ түүхэн харьцуулалтын аргыг бүтэц, ухагдахуун, ойлголтын агуулгыг шинжлэхэд туслах арга зүй хэмээн үзэх нь монголын философийг шинжлэхэд илүү оновчтой арга зүйн зарчим юм. Одоо цаашид Монголчуудын философийг авч үзэхдээ утга, ойлголтыг эдүгээчлэн шинжилдэг феноменологи, герменевтик, тодорхой бөгөөд онцлог шинжид нь анхаарал хандуулдаг бүтэц-тэмдэг зүйн шинжлэлийн зэрэг философийн арга зүйг нийгэм хүмүүнлэгийн шинжлэх ухааны ерөнхий арга зүй болох түүхэн харьцуулалтын аргатай хослуулах нь чухал юм. Монголын философичид философийн тодорхой асуудлыг шийдэж ирсэн логик, дэс дарааллыг нь эдүгээчлэн, өөрөөр хэлбэл орчин цагийн монгол хэл, ойлголт руу буулгаж ирэх, эдгээр философичид хүмүүний өмнө тавигдаж буй философийн ямар тодорхой асуудлыг шийдэхэд хувь нэмэр болж чадсан, мөн бусад соёл иргэншлийн философиос Монгол соёл иргэншлийн философи нь юугаараа ялгаатай болон онцлог болохыг харьцуулан авч үзэх зэрэг хүмүүнлэг, соёлын байр суурийг баримтлах нь зүйтэй.

Ашигласан материал:

1. Жүгдэр Ч. (2006). Монголын нийгэм-улс төр, философийн сэтгэлгээний хөгжил (МЭӨ III-МЭ XX зуун). ШУА, ФСЭХ. “Бемби сан” ХХК. Уб., 17 дахь тал
2. ФСЭХ, ШУА. (1990). Монголын философийн түүхийн зарим асуудал (Хамтын сэдэвчилсэн эмхэтгэл). ред. Лувсанцэрэн Г, Лхагвасүрэн Г. Улсын хэвлэлийн газар. Уб., 7 дахь тал
3. Anthony Thiselton. Approaching Philosophy of religion: An introduction to key Thinkers, Concepts, Methods and Debates. IV Academic. p. 44
4. ФСЭХ, ШУА. (1990). Монголын философийн түүхийн зарим асуудал (Хамтын сэдэвчилсэн эмхэтгэл). ред. Лувсанцэрэн Г, Лхагвасүрэн Г. Улсын хэвлэлийн газар. Уб., 10 дахь тал
5. ФСЭХ, ШУА. (1990). Монголын философийн түүхийн зарим асуудал (Хамтын сэдэвчилсэн эмхэтгэл). ред. Лувсанцэрэн Г, Лхагвасүрэн Г. Улсын хэвлэлийн газар. Уб., 13 дахь тал
6. ФСЭХ, ШУА. (1990). Монголын философийн түүхийн зарим асуудал (Хамтын сэдэвчилсэн эмхэтгэл). ред. Лувсанцэрэн Г, Лхагвасүрэн Г. Улсын хэвлэлийн газар. Уб., 12 дахь тал
7. Дашпүрэв Д. (2013). Монголын философийн товч түүх. ред. Дарьхүү Р. Уб., 12 дахь тал
8. Ган-Өлзий Ч. (2014). Монгол хүний сэтгэлгээний өөрчлөлт хөгжил. ШУА, Философийн хүрээлэн. “Соёмбо принтинг” ХХК. Уб., 5 дахь тал
9. Ган-Өлзий Ч. (2014). Монгол хүний сэтгэлгээний өөрчлөлт хөгжил. ШУА, Философийн хүрээлэн. “Соёмбо принтинг” ХХК. Уб., 96 дахь тал
10. Ган-Өлзий Ч. (2021). “Аргусун хуурчийн домог” шастирт философийн эргэцүүллийг олны хэлэлцүүлэг болгох аргыг хэрэглэсэн нь. Олон нийтийн дискурс дэх философийн үүрэг. Эрдэм шинжилгээний бага хурлын илтгэлийн эмхэтгэл. World Philosophy Day-2021. ШУА-ийн Философийн хүрээлэн. UNESCO Монголын Үндэсний комисс. “Соёмбо принтинг” ХХК. Уб., 18 дахь тал
11. Ган-Өлзий Ч. (2021). “Чингисийн есөн өрлөгтэй өнчин хөвгүүний сэцэлсэн шастир”-ын философийн тайлал. Философи, эрхийн судлал-XXXVI. ШУА, Философийн хүрээлэн. ред. Пүрэвсүрэн Б. “Тод бичиг” ХХК. Уб., 5 дахь тал
12. Ган-Өлзий Ч. (2021). “Чингисийн есөн өрлөгтэй өнчин хөвгүүний сэцэлсэн шастир”-ын философийн тайлал. Философи, эрхийн судлал-XXXVI. ШУА, Философийн хүрээлэн. ред. Пүрэвсүрэн Б. “Тод бичиг” ХХК. Уб., 5 дахь тал
13. Чулуунбаатар Г. (2001). Шинжлэх ухааны танин мэдэхүйн логик. ред. Дашдаваа Ч, Мандах Д. “Бемби сан” ХХК. Уб., 121 дэх тал
14. Moritz Schlick. (1992). Linguistic turn: essays in philosophical method. The future of philosophy. Edited by Richard M. Rorty. University of Chicago Press. Chicago and London., p. 54
15. Чулуунбаатар Г. (2001). Шинжлэх ухааны танин мэдэхүйн логик. ред. Дашдаваа Ч, Мандах Д. “Бемби сан” ХХК. Уб., 121 дэх тал
16. Moritz Schlick. (1992). Linguistic turn: essays in philosophical method. The future of philosophy.
17. Швырев М.С. Новая философская энциклопедия в четырёх томах. (2010). Том второй. ред. В.С.Степин. Мысль.: М., стр. 444. Edited by Richard M. Rorty. University of Chicago Press. Chicago and London., p. 54

18. Чулуунбаатар Г. (2001). Шинжлэх ухааны танин мэдэхүйн логик. ред. Дашдаваа Ч, Мандах Д. “Бемби сан” ХХК. Уб., 121 дэх тал
19. Moritz Schlick. (1992). Linguistic turn: essays in philosophical method. The future of philosophy. p. 48
20. Лодой Г. (2012). Шинжлэх ухааны судалгааны логик-арга зүйн асуудлууд (магистрантур, докторантурын сургалтын хэрэглэгдэхүүн). МУИС, Нийгмийн шинжлэх ухааны сургууль. Философийн тэнхим. 43 дахь тал
21. Лодой Г. (2012). Шинжлэх ухааны судалгааны логик-арга зүйн асуудлууд (магистрантур, докторантурын сургалтын хэрэглэгдэхүүн). МУИС, Нийгмийн шинжлэх ухааны сургууль. Философийн тэнхим. 44 дэх тал